



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 02 дугаар
сарын 05 ны өдөр

Дугаар ХЭГ/
1283


Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсад хэрэгжиж байгаа төслийн нэгжүүдийн үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэр, зорилтот үр дүндээ хүрсэн байдал, тэдгээрийн үр дүнтэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр Танд хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



 Г.ЗАНДАНШАТАР

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТООС МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулт 1. Монгол Улсын хэмжээнд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа хэдэн төслийн нэгж байгаа түүнд нийт хичнээн хүн ажиллаж байгаа тэдгээрийг төсвөөс болон гадаадын зээл, тусламжийн шугамаар хичнээн төгрөгөөр санхүүжүүлж байгаа, төслүүдийн үр дүн, зардлаа нөхөх хугацааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх талаар.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийг Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу тодорхойлж байгаа бөгөөд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хүрээнд нийт 47 төсөл хэрэгжүүлэгч нэгж байгуулсан байна. Эдгээр төсөл хэрэгжүүлэгч нэгжээс гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүждэг 43 төсөл, улсын төсвөөс санхүүждэг 4 төсөл хэрэгжүүлэгч нэгж тус тус байгаа ба нийт 369 төслийн ажилтантай, үйл ажиллагааны зардалд нэг жилд дунджаар 24.6 тэрбум төгрөгийг зарцуулж байна./ Төслүүдийн мэдээллийг (Хүснэгт 1) хавсаргав./

Монгол Улсын Засгийн газрын хувь оролцоог зээл, тусламжийн санхүүжилтийн гэрээнд тусгайлан тодорхойлон заасан тохиолдолд, тухайн төслийн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг улсын төсөвт тусган, санхүүжүүлдэг.

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн түншүүдээс авч байгаа хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнүүд нь ихэвчлэн нийгмийн үр өгөөжтэй, эргэн төлөгдөх чадваргүй, нэн ялангуяа төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлэхэд эх үүсвэр хүрэлцдэггүй дэд бүтэц, авто зам, эрчим хүч зэрэг салбарт хэрэгжиж байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д "нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр санхүүжүүлэх эсэхийг тухайн жилийн төсвийн хуулиар, шаардлагатай тохиолдолд тухай бүр шийдвэрлэх", мөн хуулийн 24.3-т "Энэ хуулийн 7.1.6-д зааснаас бусад тохиолдолд Засгийн газрын арилжааны нөхцөлтэй гадаад зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр ашиглана" гэж тус тус заасан.

Нийгмийн тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх үндсэн зорилготойгоор хөнгөлөлттэй нөхцөлтэй авч байгаа гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ нь эргэн төлөгдөх чадваргүй, нийгмийн ач холбогдолтой төслүүд байдагтай холбоотойгоор бизнесийн хөрөнгө оруулалтын төсөлтэй нэгэн адил төслийн дотоод өгөөжийн хувь хэмжээ /IRR/ болон зардлаа нөхөх хугацааг тооцдоггүй.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нэгж байгуулдаггүй.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд хэрэгжих төсөл арга хэмжээг нийгмийн үр өгөөж, ач холбогдлоор нь авч үзвэл. Үүнд:

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд нийт 127 төсөл, арга хэмжээнд нийт 945.9 тэрбум төгрөгийн нийгмийн үр өгөөжтэй төслүүд болох эрчим хүч, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн салбарын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашиглахаар төлөвлөсөн.


Тухайлбал, БНХАУ-ын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл”, “Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл”, “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн авто зам барих төсөл”, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”, Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг барих төслийг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулна.

БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Газрын тос боловсруулах үйлдвэрийг барих төсөл” шинээр хэрэгжүүлж эхлэх зэрэг томоохон төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлэн, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр төслүүдээс үргэлжлэн хэрэгжиж байгаа төслүүдийн хүрээнд дээр дурьдсаны дагуу 47 төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд байна.

Зээл, тусламжийн төслүүдийн ашиглалтыг Төсвийн ерөнхийлөн захирагчаар авч үзвэл дараах байдалтай байна.

График 1. Гадаад зээл, тусламжийн ашиглалт төсвийн ерөнхийлөн захирагч:

/сая төгрөгөөр/



1. Улаанбаатар хотын авто замын түгжрэл, нийслэл хотын дэд бүтцийг хөгжүүлэх, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр дараах томоохон төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Тухайлбал, Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, төслийн эхний шатны санхүүжилтээр нийслэл хотын Баянхошуу болон Сэлбэ дэд төвүүдийг байгуулах, энэ бүсэд амьдарч байгаа айл өрхийг инженерийн шугам, сүлжээнд холбох, дэд бүтцийн

хангамж үйлчилгээг өргөтгөх, суурь үйлчилгээний хүртээмж болон чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд:

-Улаанбаатар хотын хэмжээнд нийт тээврийн хэрэгслээр зорчиж байгаа зорчигчдын 55 хувийг хамардаг Энхтайваны өргөн чөлөөний дагуу Тусгай замын зорчих тээврийн хэрэгслийг шинээр нэвтрүүлэх замаар авто замын түгжрэлийг 2025 онд 20 хувь хүртэл, 2030 онд 30 хувь хүртэл бууруулах,

-БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Нүхэн гарц төслийн хүрээнд Нарны зам дагуу 7 байршилд төмөр замын доогуур нүхэн гарцыг байгуулж, хотын уулзваруудын нэвтрэх хурдыг нэмэгдүүлж, авто замын ачааллыг бууруулах,

-Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 метр, Сонсголонгийн 289.4 метр төмөр бетон гүүр барих төсөл, Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг сэргээн засварлах төслүүдийн хүрээнд авто замын дэд бүтцийг сайжруулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах,

-Улаанбаатар хотоос–Хөшигтийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал хүртэлх нийт 32.2 км хатуу хучилттай, 32.5 метр зорчих хэсгийн өргөнтэй, 2 урсгал, 6 эгнээтэй хурдны авто замыг тавьснаар тээврийн хэрэгслийн түргэн зорчих боломжийг нэмэгдүүлнэ.

Түүнчлэн, зам, тээврийн осол их гарч байгаа ашиглалтын хугацаа нь дууссан Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замыг өргөтгөн, шинэчилснээр зам, тээврийн ослыг бууруулахаас гадна нийслэл хотын авто замын дэд бүтцийг сайжруулна. Түүнчлэн, БНХАУ-ын Засгийн газартай тохиролцсоны дагуу “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийг 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж, эхлэхээр болоод байна.

2.Экспортыг нэмэгдүүлэх, хилийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.

-Гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих, хилийн боомтуудын нэвтрэх хүчин чадлыг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Хилийн үйлчилгээг сайжруулах төсөл”, “Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд гааль, хилийн боомтуудын дэд бүтэц, тэдгээр албаны тоног төхөөрөмжийг шинэчлэх,

-БНХАУ-ын тусламжийн хөрөнгөөр хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах зэрэг төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Тухайлбал, Замын-Үүдийн боомтын шалган нэвтрүүлэх бүсийн орох гарах урсгалын тоог нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн зорчигч тээврийн шалган нэвтрүүлэх үйлчилгээний цогцолбор төвийг байгуулахаар төлөвлөж байна.

-экспортыг дэмжих чиглэлээр Дэлхийн банкны санхүүжилтээр “Экспортыг дэмжих төсөл”, Японы ОУХАБанкны зээлийн хөрөнгөөр “Экспортын зээлийн шугам нээх төсөл”-ийг хэрэгжүүлэхээс гадна жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил

төсөл”, ХАА-н Хөгжлийн Олон улсын сангийн зээлийн хөрөнгөөр “Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл” зэрэг төслүүдийг тус тус хэрэгжүүлнэ.

3.Боловсролын салбарын хүртээмж, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулиудын тоог бууруулах, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр дараах томоохон төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төсөл”-ийн хүрээнд нийт 3 сургууль, 7 цэцэрлэгийг Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх дүүргүүд болон Дархан-Уул аймагт шинээр барих ба 8 сургууль, 17 цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргүүд болон Алтай, Говьсүмбэр, Сайншанд суманд хийхээр төлөвлөж байна.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Нийслэлийн Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд 2 сургуулийн барилга шинээр барьж, Баянзүрх, Налайх дүүрэгт 2 сургуулийн өргөтгөл хийх, БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 7 сургуулийн барилгыг нийслэлд, Архангай аймагт 1 цэцэрлэгийг шинээр барих ажлыг тус тус гүйцэтгэнэ.

4.Эрүүл мэндийн салбарын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл”-ийн хүрээнд нийслэлийн хүн амын суурьшил ихтэй Сонгинохайрхан дүүрэгт шинээр олон улсын стандартад нийцсэн жишиг нэгдсэн эмнэлэг барих, БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл”, Кувейтын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Түлэнхийн төв барих төсөл”, Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх - 2 шат” төслүүдийг хэрэгжүүлнэ.

5. Орон нутгийн хөгжлийг хангах, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.

-Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Увс, Булган болон Дундговь аймгуудад бохир усны цэвэрлэх байгууламжийг сайжруулах, шинээр барьж байгуулах,

-Францын Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төслийг дуусгаж, ашиглалтад оруулах,

-БНПУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Баян-Өлгий аймаг, Говьсүмбэр аймгийн Чойр сум, Дорнод аймгийн Чойбалсан сумдын цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Австрийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Тайшир-Алтай ус хангамж төсөл”-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн Алтай хотын усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, мөн тус улсын санхүүжилтээр Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн төвүүдийн гэр хорооллын гудамж, талбайн гэрэлтүүлэг, камержуулах,

-БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийт аймгуудын төвүүд, нийслэл хотын гудамж, талбайг камержуулах,

-БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийн хүрээнд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв, Сүхбаатар аймгуудын төвийн дулааны станцтай төвлөрсөн дулаан хангамжийн системд шилжүүлэн техник, технологийн шинэчлэлт хийнэ.

Асуулт 2. Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх төслүүдийг ямар шалгуур, үндэслэл, үзүүлэлтээр сонгож төслийн нэгж байгуулдаг, одоогоор урьдчилсан болон нарийвчилсан тэзү нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд бэлэн болсон ямар ямар төсөл, төслийн нэгжүүд байгааг салбар, яамдаар гаргаж мэдээлэх талаар.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр шинээр хэрэгжих төслүүдэд баримталдаг зарчим, хууль тогтоомжийн талаар:

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, болон бусад дунд хугацааны стратегийн баримт бичигт заасан бодлого, зорилтуудтай нийцүүлэн гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Үүний дагуу улсын төсвөөс санхүүжүүлэх боломжгүй, салбарын яамдаас ирүүлсэн тэргүүлэх зэрэглэлийн ач холбогдолтой төсөл, хөтөлбөрийг гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг санхүүжүүлэн, хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагын Монгол Улстай хамтран ажиллах дунд хугацааны хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратегийн баримт бичигт (*түншлэгч байгууллагаас хамаарч харилцан адилгүй хугацаатай байдаг бөгөөд байгуулсан стратегийн баримт бичигт тусгагдсан салбар, бодлогын зорилтын хүрээнд ирэх төсвийн жилүүдэд санхүүжүүлэх төслүүдийг тодорхойлдог*) заасан.

Үүний дагуу гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналыг хөгжлийн түншүүдэд хүргүүлдэг. Тухайн түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллага төслийн саналыг нарийвчлан судалсны үндсэн дээр төслийн агуулга, нөхцөлийг тодорхойлдог ба харилцан тохиролцсоны (*зээл, тусламжийн гэрээ ерөнхий болон тусгайлсан хэлэлцээр байгуулж, Улсын Их Хурлаар соёрхон баталсан*) үндсэн дээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлдэг.

Төсвийн тухай хуулийн 28.4-т “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.1-28.3.8-д заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийнэ.” гэж, мөн хуулийн 28.6-д “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ” гэж тус тус заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд “22.3. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө.” гэж тус тус заасны дагуу Үндэсний хөгжлийн газар нь төслүүдийн ТЭЗҮ-ийн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар, хөгжлийн түншүүдтэй хэлэлцээр хийж шинээр хэрэгжүүлэхээр болсон төслүүдийн мэдээллийг (Хүснэгт 2, 3) хавсаргав.

Асуулт 3. Төслийн нэгжүүдийг ямар нөхцөлд, ямар хугацаагаар, ямар зорилгыг хэрэгжүүлэх үүрэгтэйгээр, ямар дүрэм журмын дагуу байгуулж, үйл ажиллагаанд нь ямар хяналт тавьж, хариуцлага тооцож байгаа талаар.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаанд баримталж байгаа хууль тогтоомжууд:

Монгол Улс 1991 оноос хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд түншлэгч орон, олон улсын байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, буцалтгүй тусламжийг авч ирсэн.

Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэн, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 2015 он хүртэлх хугацаанд Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль болон түүнийг дагалдан гарсан эрх зүйн актаар зохицуулагдаж байсан.

Улсын Их Хурлын 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Өрийн удирдлагын тухай хуулийг баталсан бөгөөд өмнө нь 10 гаруй салангид хууль, тогтоомжоор зохицуулагдаж ирсэн харилцааг энэ хуулиар нэгтгэн зохицуулж байна. /Мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудын жагсаалтыг (хүснэгт 4) хавсаргав./

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийг байгуулах, тэдгээрт хяналт тавихтай холбогдсон бусад эрх зүйн акт:

Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 176 дугаар тогтоолоо батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-аар тус тус зохицуулж байна.

Эдгээр журамд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хүрээнд зээл, тусламжийг авах хэлэлцээрийн явцад тухайн төсөл, арга хэмжээний хамрах хүрээ, хүрэх үр дүн, зорилго, нэн ялангуяа төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хүний нөөцийн чадавхаас хамаарч тухайн төслийг бие даасан Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зохион байгуулалттай хэрэгжүүлэхээр санхүүжүүлэгч байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, санхүүжилтийн гэрээ, хэлэлцээрт тусгадаг.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийг төслийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор, санхүүжилтийн хэлэлцээрт тодорхойлсон дуусах хугацаатай уялдуулан, байгуулж байна. Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц, орон тоог төслийг захиалагч байгууллагын саналыг харгалзаж, дээрх журмууд болон санхүүжүүлэгч байгууллагын дотоод журмыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар байгуулдаг бөгөөд төслийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор чадварлаг боловсон хүчнийг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар шалгаруулж, төслийн ажилтан тус бүртэй Хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, төсөл хэрэгжүүлэгч нэгжийг бүрдүүлдэг.

Журамд заасны дагуу Хөлсөөр ажиллах гэрээг тухайн жилийн эцэс хүртэл байгуулж, гэрээнд заасан үүргийг жилийн эцэст дүгнэн, сунгах, шинээр байгуулах эсэхийг шийдвэрлэдэг. Хэрвээ гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө тухайн ажилтан нь ёс зүйн доголдол, аливаа зөрчил, дутагдал гаргасан тохиолдолд байгуулсан гэрээг цуцлах, үүсгэсэн зөрчил, дутагдалд журмын дагуу зохих хариуцлагыг тооцож байна.

Түүнчлэн, Төсвийн тухай хуульд Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөл хэрэгжүүлэгч нэгжийг төсвийн байгууллага байна гэж заасан бөгөөд энэхүү заалтын хүрээнд төсвийн байгууллагад тавигддаг хуульд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангуулах чиглэлээр Сангийн яамнаас тогтмол нэгдсэн зөвлөмж, удирдлагаар хангаж, санхүүжилтэд хяналт тавьж байна. Тухайлбал, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу ил тод байдлыг хангах, төсвийн гүйцэтгэлийг тайлагналд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Асуулт 4. Өнгөрсөн хугацаанд ямар, ямар төслийн нэгж, хичнээн төгрөгийн хөрөнгө оруулалт хийж үр дүнтэй хэрэгжсэн ба ямар нэгжүүд үр дүнгүй ажиллаж татан буулгасан, зорилго үр дүндээ хүрсэн эсвэл хэрэгжих боломжгүй нь тодорхой болсон төслийн нэгжүүдийг татан буулгах эсэх талаар.

Өнгөрсөн 2013-2017 оны хооронд нийт 85 төсөл хөтөлбөрийг гадаадын зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлснээс 61 төсөлд төсөл хэрэгжүүлэгч нэгж байгуулан ажилласан байна. Эдгээр 61 төсөл хэрэгжүүлэх нэгжээс 14 төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тухайн төсөл, арга хэмжээг амжилттайгаар хэрэгжүүлж дуусгавар болгосон. Үлдсэн 47 төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тухайн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Дуусгавар болсон төслөөс амжилтгүй, үр дүнгүй хэрэгжсэн төсөл байхгүй байгаа бөгөөд одоогоор татан буулгах төсөл хэрэгжүүлэх нэгж байхгүй байна.

Дээрх 61 төслийн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардалд 2013-2017 оны хооронд нийт 52.6 тэрбум төгрөгийг зарцуулсан ба 59.0 хувь нь хөнгөлөлттэй зээл, 24.6 хувь нь буцалтгүй тусламж, 13.1 хувь нь улсын төсөв, 3.3 хувь нь хоёр эх үүсвэрээс (зээл, тусламж болон улсын төсөв) санхүүжсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардал нь тухайн төслийн онцлог, ач холбогдол, хамрах хүрээ зэргээс хамааран харилцан адилгүй байдаг бөгөөд төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын жилийн жигнэсэн дундаж хэмжээ 318.4 сая төгрөг байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг (хүснэгт 5) хавсралтаар үзүүлэв./

Асуулт 5. Төслийн нэгжүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, бүтэц, удирдлага, зөвлөх үйлчилгээний зардал нийт хэдэн хувийг эзэлж байгаа, тухайн төслүүд нь зээлээр хэрэгждэг бол зээлийн хугацаа, хүүгийн талаарх мэдээллийн талаар:

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн санхүүжилтийн эх үүсвэр нь харилцан адилгүй байгаа бөгөөд Зээлийн хэлэлцээрт тусгайлан Монгол Улсын Засгийн газрын хувь оролцоотой хэрэгжүүлэхээр заасан бол гэрээний заалтын дагуу улсын төсвөөс санхүүжүүлдэг.

Одоо хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс нийт 47 төсөл хэрэгжүүлэгч нэгжийг байгуулан үйл ажиллагаа явуулж байгаагаас 4 төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа бол үлдсэн 43 төсөл хэрэгжүүлэгч нэгж тухайн төслийн эх үүсвэрээс санхүүжин, үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн, Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, тэдгээрийн санхүүжилтийн хэлэлцээрт заасан нөхцөл нь төслийн зорилго, хамрах хүрээ, ач холбогдол зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг бөгөөд төслийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохдоо төслийг хэрэгжүүлэгч байгууллага, зээлдүүлэгч талтай харилцан тохиролцдог.

Тухайлбал, төслийн зорилго нь институцийн чадавхийг бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход түлхүү чиглэгдсэн төсөл арга хэмжээнүүдийн төслийн бүрэлдэхүүн хэсэгт Зөвлөх үйлчилгээний зардал нь дийлэнх хувийг эзэлж байдаг бол тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн бүрэлдэхүүнд эзлэх хөрөнгийн зардал 100 хувь байдаг.

Бүтээн байгуулалтын төслүүдийн хувьд төслөөс хамааран тодорхой хувь нь зөвлөх үйлчилгээний *(ихэнх тохиолдолд зураг, төсөв, ТЭЗҮ хийх, гүйцэтгэлд техникийн хяналт хийх ажлыг төслийн зөвлөхөөр сонгогдсон хуулийн этгээд хийж, гүйцэтгэдэг)* байна. /Хэрэгжиж байгаа төслүүдийн бүрэлдэхүүнд зөвлөх үйлчилгээний зардлын эзлэх хувь хэмжээг үзүүлсэн мэдээллийг (Хүснэгт 6) хавсаргав./

Монгол Улсын эдийн засаг Үндэсний нийт орлогын аргаар тооцсон ангиллаар 1991-2014 он хүртэл хугацаанд бага, бага-дунд орлоготой орны ангилалд багтаж байсан бол 2014 оноос эхлэн дунд орлоготой орны ангилалд шилжсэн. Үндэсний нийт орлогын хэмжээнд суурилсан Атласын аргачлалаар тооцож байгаа энэхүү үзүүлэлтээс хамаарч олон улсын санхүүгийн байгууллагууд нь тухайн улсад олгох зээлийн нөхцөл, хөнгөлөлтийн түвшнийг жил бүр шинэчлэн, тодорхойлж байдаг. Үүнтэй холбоотойгоор, хөнгөлөлттэй зээлийн хүүгийн түвшин сүүлийн жилүүдэд өсч, зээлийн хугацаа багасч байгааг (Хүснэгт 7) хавсаргав.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газарт олгох зээл нь шилжилтийн эдийн засгийн эхэн үед хэмжээ бага, хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн хүндрэлийг даван туулах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, институцийн чадавхийг бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдэж ирсэн бол сүүлийн жилүүдэд манай эдийн засгийн хурдацтай өсөлт, төлбөрийн чадвар сайжрах хирээр томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг олгох болсон.

Улсын Их Хурлаас 2006 онд баталсан Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн дагуу Монгол Улсын Засгийн газар зөвхөн хөнгөлөлттэй зээл авах эрх, зүйн зохицуулалттай байсан бол Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр батлагдсанаар арилжааны нөхцөлтэй зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг ашиглах боломж бүрдсэн юм. /Мэдээллийг (Хүснэгт 8) хавсаргав./

Асуулт 6. Үйл ажиллагаа нь түр болон бүр зогссон, нэмэлт хөрөнгө шаардлагатай төслийн нэгжүүдийн талаар.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдээс 47 төсөл хэрэгжүүлэгч нэгж одоогоор үйл ажиллагаа явуулж байгаагаас Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа түр зогсоход хүрээд байна.

Уг төсөл нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө (9.5 сая евро) болон Монгол Улсын хувь оролцоотойгоор (2.5 сая евро) Эрдэнэт хотод хэрэгжиж байгаа бөгөөд тус хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн, хүчин чадлыг нэмэгдүүлснээр хот өргөжин тэлэх, өсөн нэмэгдэж байгаа үйлдвэр, орон сууцны барилгад шаардлагатай суурь дэд бүтцийг бүрдүүлж, улмаар хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

Гадаадын зээлийн хөрөнгөөр төслийн зөвлөх болон тоног, төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх бол төсөл хэрэгжүүлэгч нэгж болон төслийн хүрээнд баригдах байгууламжтай холбогдолтой зардлыг Засгийн газар хооронд байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газар хариуцахаар заасан ба үүний дагуу төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг.

Төслийн үйл ажиллагааг 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс эхлүүлж, 2017 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөр дуусгавар болгохоор төлөвлөсөн байсан ч барилгын өргөтгөлийг хийж байгаа гүйцэтгэгч дотоодын аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас хамаарч төслийн хэрэгжилт удааширсан нь төсөл сунгагдах нөхцөлийг бүрдүүлсэн.

Төсөл хэрэгжүүлэгч Барилга, хот байгуулалтын яам болон Орхон аймгийн Засаг даргын Тамгын газраас 2017 оны 9 дүгээр сарыг хүртэлх хугацаанд 2017 оны 10 дугаар сард Улсын комисс байгуулан барилга, байгууламжийг улсад хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байсан тул гадаад зээлийн ашиглалт, зарцуулалт болон төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны урсгал зардлыг 2018 оны улсын төсөвт тусгуулах саналыг Монгол Улсын 2018 оны төсвийн төслийг боловсруулах явцад Сангийн яаманд ирүүлээгүйн улмаас санхүүжүүлэх эх үүсвэргүй болсон. Өөрөөр хэлбэл, төслийн

хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд дуусгавар болгоогүй, төсөл сунгагдах болсноор төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй болоод байна.

Энэхүү төслийн хэрэгжилт болон зээлийн ашиглалт 94.0 хувьтай байгаа нь төслийг хэрэгжүүлж дуусгах зайлшгүй нөхцөл, шаардлагыг бий болгож байна.

Асуулт 7. Цаашид төслийн нэгжүүдийн үйл ажиллагааг үр дүнтэй, ил тод, хуулийн дагуу явуулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.

Монгол Улсын эдийн засаг зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний үед гадаад орон, олон улсын байгууллагуудаас авсан хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүнээс 1.6 дахин их хэмжээнд хүрч, шилжилтийн үеийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Түүнчлэн, гадаад зээл, тусламжийн эх үүсвэр нь цаашид ч Засгийн газрын санхүүжилтийн шаардлагатай хэрэгцээг шийдвэрлэх чухал эх үүсвэр хэвээр байна.

Энэ нь ирэх төсвийн жилүүдэд Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдал, төсвийн мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй Засгийн газрын өрийн үйлчилгээний ачааллыг жигдэлж багасгах, өрийн дарамтыг бууруулах зайлшгүй шаардлага үүсээд байгаатай холбоотой.

Нөгөөтэйгүүр, Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн олон улсын байгууллагад элсэн орж, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл, тусламжийн эх үүсвэрийг авч ашиглаж эхэлсэн үеэс эхлэн энэхүү харилцаанд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актыг үе шаттайгаар шинэчлэн, сайжруулж ирсэн.

Өнөөгийн нөхцөл байдалд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн нэгжүүд, тэдгээрийн ил тод байдлыг хангах харилцаа нь Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон эдгээр хуулийг дагаж гарсан журам, эрх зүйн актаар зохицуулагдаж байна. Цаашид ч эдгээр мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудыг шинэчлэх шаардлага үүсээд байна.

Гадаадын зээл, тусламжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төслүүдийн хяналт-шинжилгээ үр дүнг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

Гадаадын зээл, тусламжийн талаар мөрдөгдөж байгаа эрх зүйн акт, журам зааврыг боловсронгуй болгохоор хөгжлийн түншүүд, төслийг хэрэгжүүлэгч байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд салбарын хэрэгжүүлж байгаа төслүүдийн зорилго, цар хүрээ зэргээс хамаарч, нэн ялангуяа төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдэд хамааралтай нормативыг өөрчлөх хувилбарыг боловсруулан, шинэчлэх ажлыг зохион байгуулж байна.

Түүнчлэн, Өрийн удирдлагын тухай хуульд Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг Улсын Их Хурал тодорхойлох бүрэн эрхтэй талаар заасны дагуу Сангийн яамнаас тус бодлогын баримт бичгийн төслийг боловсруулаад байна. Цаашид энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулж Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, Засгийн газрын хуралдаанаар тайланг хэлэлцүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж байгаа бөгөөд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид өөрийн салбар, эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн 2017 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгсөн тайланг нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн танилцуулахаар ажиллаж байна.

Мөн, Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд төслүүдийн хэрэгжилт, гүйцэтгэлийг тайлагнах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа төслүүдийг нэгтгэн дүгнэх, санхүүжүүлэгч талд Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа, салбарын бодлого, тэргүүлэх чиглэлийн баримт бичгүүдийг танилцуулж, тэдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг тодорхойлж, мэдээлэл харилцан солилцох зорилгоор зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг сэргээн зохион байгуулах”-аар тусгасны дагуу Засгийн газар-Хөгжлийн түншүүдийн зөвлөлдөх уулзалтыг 2016 оны 12 дугаар сарын 2-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

Уг уулзалтаар Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл болон салбарын зорилтууд, макро эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээний тухай танилцуулан, хөгжлийн түншүүд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын зорилт, хүрэх үр дүнг хангах хүрээнд уялдсан үндэсний стратеги, тэргүүлэх, чиглэл бодлого зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахаа илэрхийлсэн.

Цаашид Засгийн газар болон гадаад түншүүдийн зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулах, үйл ажиллагааны үр өгөөж, мэдээллийн ил тод байдал, бодлогоо нээлттэй хэлэлцүүлэх, харилцан итгэлцэл, хариуцлагатай үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжиж ажиллахаар тогтсон.

Энэхүү хамтын ажиллагааны зохицуулалтын механизм нь хөгжлийн түншүүдтэй харилцах харилцааг өргөжүүлэн бэхжүүлэх, Засгийн газрын зүгээс хөгжлийн бодлого, үндсэн чиглэлд заасан зорилтыг хөгжлийн түншүүдийн зээл, тусламжийн эх үүсвэртэй уялдуулах, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр ашиг, хэрэгжилтийг эрчимжүүлэх, хөгжлийн түншүүдтэй хамтарч ажиллах хүрээ, чиглэлийг тодорхойлох, нэгдсэн ойлголтод хүрэхэд өндөр ач холбогдолтой бөгөөд дараагийн зөвлөлдөх уулзалтыг 2018 оны эхний хагас жилд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Түүнчлэн салбарын бодлого, тэргүүлэх чиглэлийн зорилт, хэрэгжилтийг хөгжлийн түншүүдтэй хэлэлцэх, салбарын яам, хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд болон хөгжлийн түншүүдийн үйл ажиллагааг уялдуулах хүрээнд салбарын болон сэдэвчилсэн уулзалтуудыг яамд, хөгжлийн түншүүдтэй хамтран зохион байгуулах, салбарын зээл, тусламжийг зохицуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар ажиллаж байна. Өнгөрсөн онд эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр, барилга, хот байгуулалтын салбарт хөгжлийн түншүүдийн салбарын зөвлөлдөх уулзалтыг амжилттай зохион байгуулав.

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлэлт, дүгнэлт өгөх уулзалтыг хөгжлийн түншүүдтэй хамтран зохион байгуулах, уулзалтаар төслүүдийн үйл ажиллагаа, хэрэгжилтэнд тулгарч байгаа нийтлэг асуудлыг тодорхойлон хэлэлцэх, шийдвэрлэх боломжийн талаар санал солилцох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Төслүүдийн дансыг Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжүүлэх талаар:

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн данс нь зарим арилжааны банкуудад байршиж байгааг Төрийн сангийн нэгдсэн дансанд төслийн үйл ажиллагаанд хүндрэл үүсгэлгүйгээр үе шаттайгаар шилжүүлэх, улмаар Төрийн сангийн нэгдсэн данснаас төлбөр тооцоог хийж, гүйцэтгэх тогтолцоонд шилжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сангийн яамнаас Монголбанктай холбогдох уулзалтуудыг хийж, системийг өргөтгөх, шаардлагатай бэлтгэл ажлыг хангах чиглэлээр арга хэмжээг авч байна. Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд Сангийн яамны зүгээс төслийг хэрэгжүүлэгч байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчид болон санхүүжүүлэгч талтай олон талт уулзалтуудыг тухай бүр зохион байгуулан, хамтран ажиллаж байна.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээний системийг боловсронгуй болгох талаар:

Түншлэгч орон, олон улсын байгууллагаас авч байгаа хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц байдал, үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор 2016 оноос эхэлж төслүүдийн хүрэх үр дүн, хэрэгжилт, санхүүжилтийн хэмжээ хэрэгжүүлэгч байгууллага, гүйцэтгэгч, ашиглалт зэрэг төсөлтэй холбоотой мэдээллийг агуулсан Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн Удирдлагын мэдээллийн систем /ODAMIS/-ийг Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд тусламжийн хөрөнгөөр бий болгосон.

Уг системийг Сангийн яамны цахим хуудсаар дамжуулан ажиллуулж байгаа ба системд 1991 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газрын авч ашигласан гадаадын

зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан болон хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг оруулаад байна.

Хэдийгээр төслүүдийн мэдээллийг оруулан, системийг ашиглаж байгаа ч цаашид системийн мэдээллийн санг өргөжүүлэн шинэчилж, мэдээллийн агуулга, чанарыг сайжруулах шаардлага үүссэн. Үүний дагуу хэрэглэгчдэд мэдээлэл авахад илүү хялбар болгож системийг өөрчлөх, модуль, өгөгдлийн сан, интерфэйсийн шинэчлэлт, өөрчлөлтүүдийг системд хийхээр ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр ашгийг нэмэгдүүлэхэд үргэлжлүүлэн анхаарч ажиллах талаар.

Шилэн дансны тухай хуулиар тодорхойлсон Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагад мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх, тайлагнах, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Сангийн яамнаас үүрэг чиглэл хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд байгуулагдсан төсөл хэрэгжүүлэгч нэгж, түүний орон тоо, үйл ажиллагааны зардлын тооцоолол	2
Хүснэгт 2. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийн нэгж болон төслийн ТЭЗҮ-ийн талаарх мэдээлэл	10
Хүснэгт 3. Гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийн нэгж болон төслийн ТЭЗҮ-ийн талаарх мэдээлэл	14
Хүснэгт 5. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан болон, хэрэгжиж байгаа төсөл,	16
арга хэмжээний үйл ажиллагааны зардлын мэдээлэл	16
Хүснэгт 6. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний бүрэлдэхүүний хүрээнд зөвлөх үйлчилгээний зардалтай холбоотой мэдээлэл	18
Хүснэгт 7. Санхүүжүүлэгч талын 1991-2017 оны зээлийн нөхцөлүүдийн харьцуулалт	20
Хүснэгт 8. Улсын Их Хурлаас соёрхон баталсан Зээлийн хэлэлцээр, тэдгээрийн нөхцөлүүдийн мэдээлэл	21

Хүснэгт 1. 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд байгуулагдасан төсөл хэрэгжүүлэгч нэгж, түүний орон тоо, үйл ажиллаганы зардлын тооцоолол

сая төгрөг

№	Төсвийн ерөнхийлөн захиралч /Төсөл арга, хэмжээ/	Банхүүжүүлэгч	Хэрэгжүүх хугацаа	Төрөл	ТХН-ийн орон тоо	Улсын төсвөөс санхүүжих	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	ТХН-ийн үйл ажиллагааны жилийн дундаж дараал	Төслийн үндсэн зорилго, ач холбогдол
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА									
1	Монгол Улс дахь төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх	Нэгдсэн үндэстний байгууллага	2017-2020	тусламж	4		242.6	242.6	НӨУБ-ын эрх зүйн болон институтийн харилцан уялдаатай асуудлууд, ИТХ-ын зохион байгуулалтын /хувьд болон хувь төлөөлөгчдийн чадавхыг бэхжүүлэх замаар дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх.
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА									
2	Ухаалаг засаг төсөл	Дэлхийн банк	2015-2020	хөнгөлөлт-тэй зээл	5		271.7	271.7	Мэдээлэл, харилцаа холбооны технологийг оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, ил тод болон үр ашигтай болгон сайжруулах.
3	Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төсөл	Дэлхийн банк	2016-2018	тусламж	4		307.8	307.8	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг тогтвортой оролцооны зарчим дээр хэрэгжүүлснээр Монголын олборлох үйлдвэрлэлийн удирдлагын нээлттэй, харилцаатай байдлыг сайжруулах.
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД									
